



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2024 оны 01 сарын 22 өдөр

Дугаар А/25

Арвайхээр сум

Дэмжлэг үзүүлэх тухай

Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.6, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн "Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай" 03/03 дугаар тогтоолоор батлагдсан хөтөлбөрийн 1.3.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Америкийн Нэгдсэн Улсын Лос Анжелос хотод зохион байгуулагдах цээж тоолол, соробан сампингийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд оролцохоор шалгарсан Мэргэд ерөнхий боловсролын сургуулийн ба ангийн сурагч Э.Наранбатын тэмцээний зардалд 2,000,000 (хоёр сая), тус сургуулийн 4а ангийн сурагч Э.Батнарангийн тэмцээний зардалд 2,000,000 (хоёр сая), нийт 4,000,000 (дөрвөн сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дээрх 4,000,000 (дөрвөн сая) төгрөгийн зардлыг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т зөвшөөрсүгэй.

ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



И.ДОРЖСҮРЭН

8024 11 0049